



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 311

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Амгалан дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 483,153,697.21 (дөрвөн зуун наян гурван сая нэг зуун тавин гурван мянга зургаан зуун ерэн долоон төгрөг хорин нэгэн мөнгө) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Амгалан дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Амгалан дулааны станц” төрийн өмчит хувьцаат Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нь Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3.2 дахь заалтыг ханган ажиллаагүй байх тул зохих хариуцлага тооцож, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Батзориг-д үүрэг болгосугай.

3. “Амгалан дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (М.Мөнхөө)-д Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2. Үйлдвэрлэлийн хэсгийн өргөтгөл шинэчлэлтийн хүрээнд бий болсон нийт 68,415,481,820.62 (жаран найман тэрбум дөрвөн зуун арван таван сая дөрвөн зуун наян нэгэн мянга найман зуун хорин төгрөг жаран хоёр мөнгө) төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн үндсэн хөрөнгийн дансны ангилал тус бүрээр бүртгэх;

3.3. Үндсэн хөрөнгийн шинж чанараа алдаж, зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон 15 нэр төрлийн, 19 ширхэг үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг акталж данснаас хасах, 6 нэр төрлийн, 41 ширхэг элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг акталж данснаас хасах болон цаашид ашиглах боломжтой хөрөнгийг ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх;

3.4. Техник, технологийн зайлшгүй шаардлагаар буусан 452,907,429.2 (дөрвөн зуун тавин хоёр сая есөн зуун долоон мянга дөрвөн зуун хорин есөн төгрөг

хоёр мөнгө) төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу шийдвэрлүүлэх;

3.5.Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах.

3.6.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

3.7.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 55 дугаар тогтоолын 3.4 дэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.

4.Тогтоолын биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн
3 дугаар тогтоолын хавсралт



**“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД
ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫГ
АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн (төгрөг)	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Зориулалт бусаар зарцуулсан зардал	2,481,368.00	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэнтэй нийцэхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 1.1-д Төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах
2	Буусан хөрөнгийн талаар	452,907,429.2	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай журмын 6.1-д зааснаар Төрийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэ журамд заасан баримт материалын хамт хагас жилд 1 удаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлэнэ. 6.2.3-д зааснаар Текник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шаардлагатай болсон бол Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээд данснаас хасна
3	Төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан талаар	27,764,900.01	Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3.2. дахь хэсэгт “... эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг үзүүлэлт бүрээр биелүүлэх үүрэгтэй.
НИЙТ ДҮН		483,153,697.21	(дөрвөн зуун наян гурван сая нэг зуун тавин гурван мянга зургаан зуун ерөн долоон төгрөг хорин нэгэн) мөнгө